



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/91

Мандалговь

“Ашид бьюлдинг” ХХК-тай гэрээ байгуулах
тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”- 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн А/39 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих Соёлын төвийн барилгын их засвар ажил (Дундговь, Дэрэн сум) ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Ашид бьюлдинг” ХХК-тай 92,004,793 (ерэн хоёр сая дөрвөн мянга долоон зуун ерэн гурав) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг, төсвийн дагуу Соёлын төвийн барилгын их засварын ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Ашид бьюлдинг” ХХК-ны гүйцэтгэх захирал (О.Мөнхсаруул)-д үүрэг болгосугай.

Гурав.Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Дэрэн сумын Засаг дарга (Н.Мядагмаа), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060386